



ӨСВӨР ҮЕ ХҮНС ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

「Үндсэн цалинг шинэчлэн тогтоох тухай」

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4/, 20.1.10/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.1, 102 дугаар зүйлийн 102.1.2, 102.1.3, 107 дугаар зүйлийн 107.1, Нийслэлийн Засаг даргын “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин” батлах тухай 2023 оны А/688 дугаар захирамж, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7.5 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2023 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинд цалингийн сан нэмэгдэж батлагдсан тул хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлт, инфляцын түвшин, үнийн өсөлт болон үйл ажиллагааны цар хүрээ тэлэхийн хэрээр хөдөлмөрийн бүтээмж өсөж, ажлын ачаалал нэмэгдсэнтэй уялдуулан нийт ажилтнуудын сарын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлж, ажлын байр, албан тушаалын байдлаар нь хавсралтад зааснаар тогтоосугай.

2. Цалингийн санг бүтэн жилээр тооцож баталсан тул шинэчлэн тогтоосон цалинг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож, байгууллагын цалингийн сангаас олгохыг ерөнхий нягтлан бодогч (Ш.Отгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Г.МӨНХЗУЛ

3130600058